ХАСБАНК ХК

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан талаарх мэдээлэл

Тухай бүр мэдээлэх мэдээлэл /маягт 3/		
Тайлагнах хугацаа	2026 оны 10 дугаар сарын 16-ны өдөр	
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Нэр:	ХасБанк ХК
	УБГД:	000239852
	РД:	2578697
	Үнэт цаасны код:	MN00XAC05687
	Хаяг:	Монгол улс, Улаанбаатар хот, СБД, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72
	Утас:	75771888
	И-майл:	info@xacbank.mn
	Вэбсайт:	www.xacbank.mn
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж ТӨХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүүгийн салбар	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000 ширхэг энгийн хувьцаа	
Тухай бүр мэдээлэх мэдээллийг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Н.Цэлмэгхишиг, ТУЗ-ийн ажлын албаны хуульч Хянасан: Н.Мөнхцэлмэг, Хууль, хянан нийцүүлэлт хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	

1.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан талаарх мэдээлэл
	ХасБанк ХК (“**Банк**”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хооронд эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулагдсан ээлжит бус хурлаар 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах асуудал батлагдсан ба Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.11 дэх хэсэгт заасны дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл тус хурлын үр дүнг 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн R-2026-41 дүгээр тогтоолоор хүлээн зөвшөөрсөн болно.

XACBANK

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:
Овог, нэр: Н.Цэлмэгхишиг Албан тушаал: ТУЗ-ийн ажлын албаны хуульч Гарын үсэг: Хянасан: Н.Мөнхцэлмэг Албан тушаал: Хууль, хянан нийцүүлэлт хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Гарын үсэг: Огноо: 2026 он 10 сар 16 өдөр



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ХАСБАНК

20 26 оны 10 сарын 09 өдөр № SR-2026-06 Улаанбаатар хот

2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас
ногдол ашиг зарлан хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК ("**Банк**")-ийн Дүрмийн 8.6(ii) дахь заалтыг тус тус үндэслэн, 2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан эчнээ санал хураалтаар Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Ногдол ашиг хуваарилах эсэх нь Банкны Дүрэмд заасан стратегийн асуудал тул Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал эцэслэн батлах шаардлагатай болохыг;

2. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("**ТУЗ**") Банкны 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг мөнгөн хэлбэрээр хуваарилах ("**Хагас жилийн ногдол ашиг**")-ыг 2026 оны 08 дугаар сарын 20-ний өдрийн R-2026-37 дугаар тогтоолоор Хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг; мөн

3. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс санал болгосны дагуу Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, Банкны Дүрмийн 8.6(ii) дахь заалтыг үндэслэн дор дурдсан дүнгээр Хагас жилийн ногдол ашгийг зарлан хуваарилахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Хагас жилийн ногдол ашигт нэгж хувьцаанд 18 (арван найм) төгрөг зарлан хуваарилсугай.

2. Монголбанкны зөвшөөрлийг хүлээн авсан өдөр эсхүл энэхүү тогтоол батлагдсан өдрийн аль сүүлийн өдрөөс хойш 7 хоногийн дотор Хагас жилийн ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр төлсүгэй. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" 28 дугаар тогтоолд заасны дагуу, Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь банкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА САНЖАЙ ГУПТА

ХАСБАНК
УХН4937 2578697

ХАСБАНК
ХУУЛБАР УЖИЛ CERTIFIED TRUE COPY
...../албан тушаалын нэр/position/
...../гарын үсэг/signature/
...../гарын үсгийн тайлал/name/
Огноо/Date .....

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ХАСБАНК

20 26 оны 10. сарын 15 өдөр № R-2026-41 Улаанбаатар хот

Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын үр дүнг хүлээн зөвшөөрөх тухай

Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.11 дэх хэсэгт заасны дагуу ХасБанк ХК (**"ХасБанк"**)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (**"ТУЗ"**) 2026 оны 10 дугаар сарын 12-15-ны өдрийн хооронд зохион байгуулсан цахим санал хураалтын үр дүнд дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. ХасБанк нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (**"ХЭЭБХ"**)-ыг 2026 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 10 дугаар сарын 09-ний өдрийн хооронд, ХасБанкны 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах асуудлыг шийдвэрлүүлэхээр эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулсан болохыг;

2. ТУЗ-ийн 2026 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн R-2026-38 дугаар тогтоолоор байгуулагдсан Тооллогын комисс нь Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн саналыг хүлээн авч, санал хураалтын дүнг нэгтгэсэн тайланг 2026 оны 10 дугаар сарын 12-ны өдөр ТУЗ-д хүргүүлсэн болохыг; мөн

3. Тооллогын комисс нь ХасБанкны Дүрмийн 8.6 дахь хэсэг болон 1.5.25 дахь заалтад заасны дагуу эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулсан ХЭЭБХ-д нийт 803,361,967 ширхэг хувьцааг буюу нийт гаргасан хувьцааны 76.5%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсон тул хурлыг хүчин төгөлдөрт тооцсон болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулсан ХЭЭБХ-ын үр дүнг Тооллогын комиссын танилцуулсан ёсоор дараах байдлаар хүлээн зөвшөөрсүгэй:

   i. ХасБанкны 2026 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах тухай асуудлаар:

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн		Санал өгөөгүй	
Хувьцааны тоо	Хувь	Хувьцааны тоо	Хувь	Хувьцааны тоо	Хувь	Хувьцааны тоо	Хувь
803,361,102	99.99%			865	0.001%		

ХАСБАНК
ХУУЛБАР ҮНЭН/CERTIFIED TRUE COPY
.....Албан тушаалын нэр/position/
.....Гарын үсэг/signature/
.....Гарын үсгийн тайлал/name/
Огноо/Date .....

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

2. ХасБанкны Дүрмийн 8.9 дэх хэсэгт заасны дагуу ХЭЭБХ-ын даргын хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолд гарын үсэг зурахыг ТУЗ-ийн дарга Санжай Гүптад даалгаж, холбогдох эрхийг олгосугай.

3. Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээ авахыг даалгаж, холбогдох эрхийг олгосугай.

4. Хууль, хянан нийцүүлэлт хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт Компанийн тухай хуульд заасан хугацаанд, холбогдох журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг нийтэд мэдээлэхийг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА САНЖАЙ ГҮПТА

ХУУЛЬ, ХЯНАН НИЙЦҮҮЛЭЛТ
ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.МӨНХЦЭЛМЭГ